



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Яруу сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ЗАА-2026/019/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn



Улиастай сум

2026 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор: Т.Баасанжаргал

Утас: 92012266

Цахим хаяг: Baasanjargalt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс: 7046-3612
Цахим нууцан: zavkhan@audit.gov.mn

2026.03.24 № 248
тантай _____ -ны № _____ -т

ЯРУУ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ГАНЗОРИГТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Яруу сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Яруу сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Яруу сумын Засаг дарга нь Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зарим иргэдийн зээлийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн хэрэгжээгүй зөрчилд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 15.4.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4-т "Сум дүүргийн Засаг даргын чиг үүрэг", 3.4.3-т "Сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих", Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3.4-т "Сангийн үйл ажиллагааны талаар сумын Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 3.4.3-т "Төслийг хэрэгжүүлэх этгээдтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих", 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд

D:\Албан бичиг\А4-2026.docx

төвлөрүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд урсгал санхүүжилтийн орлого 228,897.6 мянган төгрөгөөр, улсын төсөвт байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгох байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт 131,413.9 мянган төгрөгөөр тус тус өссөн, нэмэлт санхүүжилтийн орлого 87,673.2 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 57,005.6 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Аудитын гол асуудал

Яруу сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийхэд хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой 82,302.0 мянган төгрөгийн материаллаг зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Яруу сумын Засаг дарга нь тайлант онд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 24,620.9 мянган төгрөгийг 19 иргэнд буцаан олгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		374,294.7	346,917.3
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	124,378.1	146,789.1
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	205,244.3	161,162.3
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	44,672.3	38,965.9
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		754,485.6	728,157.1
6	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	754,485.6	728,157.1
7	Биет хөрөнгө		742,590.1	716,866.4
8	Биет бус хөрөнгө	13	11,895.5	11,290.7
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		1,128,780.3	1,075,074.5
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,600	36,259.4
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,600	36,259.4
12	Өглөг		1,600	36,259.4
13	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,127,180.3	1,038,815.1
14	Засгийн газрын хувь оролцоо		1,127,180.3	1,038,815.1
15	Засгийн газрын оруулсан капитал		312,513.8	312,513.8
16	Хуримтлагдсан үр		681,916.3	593,551.1
17	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		132,750.2	132,750.2
18	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		1,128,780.3	1,075,074.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		1,914,358.3	1,659,058.8
2	ТАТВАРЫН ОРЛОГО		276,142.8	380,849.1
3	Орлогын албан татвар		205,966.3	234,789.7
4	Хувь хүний орлогын албан татвар		226,810.1	259,410.7
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-21,828	-24,621
6	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		984.2	0.0
7	Хөрөнгийн албан татвар		33,457.8	66,805.4
8	Бусад татвар, төлбөр, хураамж		36,718.7	79,254
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	432,109.5	1,278,209.8
10	Тусламжийн орлого		0.0	947,261.4
11	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,206,106.1	0.0
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,283,840.6	1,476,213
13	УРСГАЛ ЗАРДАЛ		1,283,840.6	1,476,213
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,200,368.6	1,418,929.5
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		590,054.6	683,105.2
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		71,756	87,009.2
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		247,871.3	380,195.9

18	Хангамж, бараа материалын зардал		80,307.6	92,372.3
19	Норматив зардал		350	0.0
20	Эд хогшил, урсгал засварын зардал		10,309.4	11,787.6
21	Томилолт, зочны зардал		13,829.7	7,927.2
22	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		29,771.2	13,029.7
23	Бараа үйлчилгээний бусад зардал		156,118.8	143,502.4
24	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		83,472	57,283.5
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		630,517.7	182,845.9
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		285,898	271,211.1
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-285,898	-271,211.1
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		344,619.8	-88,365.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	782,560.6	782,560.6
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	782,560.6	782,560.6
3	Тайлант үеийн үр дүн	344,619.8	344,619.8
4	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	1,127,180.3	1,127,180.3
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,127,180.3	1,127,180.3
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,127,180.3	1,127,180.3
7	Тайлант үеийн үр дүн	-88,365.2	-88,365.2
8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,038,815.1	1,038,815.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,566,126.9	1,606,263.7
2	ТАТВАРЫН ОРЛОГО	276,142.8	380,849.1
3	Орлогын албан татвар	205,966.3	234,789.7
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-21,828	-24,621
5	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	984.2	0.0
6	Хөрөнгийн албан татвар	33,457.8	66,805.4
7	Бусад татвар, төлбөр, хураамж	36,718.7	79,254
8	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,483.4	2,122.1
9	Газрын төлбөр	10,644.2	17,172.5
10	Байгалийн нөөц ашигласны төлбөр	24,591.1	59,959.4
11	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,878.1	1,225,414.6
12	Нийтлэг татварын бус орлого	83,878.1	81,228.9
13	Тусламжийн орлого	0.0	947,261.4
14	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	196,924.3

15	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,206,106.1	0.0
16	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,247,578.6	1,367,462.6
17	УРСГАЛ ЗАРДАЛ	1,247,578.6	1,367,462.6
18	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,164,106.6	1,309,906.9
19	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590,054.6	684,018.9
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,756.1	87,107.6
21	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,871.3	379,285.3
22	Хангамж, бараа материалын зардал	43,664.9	25,361.7
23	Эд хогшил, урсгал засварын зардал	10,235.8	14,359.2
24	Томилолт, зочны зардал	12,259.7	9,497.2
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,792.8	20,826.7
26	Бараа үйлчилгээний бусад зардал	154,471.4	89,450.2
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,472	57,555.8
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	318,548.3	238,801
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	300,823.2	214,260.8
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	300,823.2	214,260.8
31	Дотоод эх үүсвэрээр	300,823.2	214,260.8
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-300,823.2	-214,260.8
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	99,835.9	2,129.3
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-99,835.9	-2,129.3
35	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-82,110.8	22,410.9
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	206,488.9	124,378.1
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	124,378.1	146,789.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	2025 оны 12-р сарын 31
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,801,779.7	1,586,666.5
2	Татварын орлого	420,059.7	380,849.1
3	Орлогын албан татвар	324,119.7	234,789.7
4	Хувь хүний орлогын албан татвар	347,947.7	259,410.7
5	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	232,047.7	212,610.3
6	Үйл ажиллагааны орлого	24,000	29,544.3
7	Хөрөнгийн орлого	90,200	0.0
8	Хөрөнгө борлуулсны орлого	500	0.0
9	Шууд бус орлого	1,200	17,256.1
10	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-23,828	-24,621
11	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-23,828	-24,621
12	Хөрөнгийн албан татвар	28,980	66,805.4
13	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,200	14,261.7
14	Бууны албан татвар	3,150	3,416
15	Малд ногдуулах албан татвар	23,630	49,127.7
16	Бусад татвар, төлбөр, хураамж	66,960	79,254
17	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,450	2,122.1
18	Улсын тэмдэгтийн хураамж	1,450	1,478.1
19	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500	100

20	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,500	544
21	Газрын төлбөр	19,000	17,172.5
22	Газрын төлбөр	19,000	15,861.3
23	Дуудлага худалдаа	0.0	1,311.2
24	Байгалийн нөөц ашигласны төлбөр	44,510	59,959.4
25	Ойн нөөц ашигласны төлбөр	8,800	4,172.4
26	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	35,000	55,387
27	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	400	300
28	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	310	100
29	Татварын бус орлого	1,381,720.0	1,205,817.4
30	Нийтлэг татварын бус орлого	244,833	81,229
31	Хүүгийн орлого	22,496.4	33,987.5
32	Торгуулийн орлого	3,000	1,661.5
33	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	219,336.8	45,579.9
34	Тусламжийн орлого	927,664.2	927,664.2
35	Аймаг нийслэлээс авсан татаас	563,608	563,608
36	Төсвийн санхүүжилт	364,056.2	364,056.2
37	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	209,222.6	196,924.3
38	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,720,647.2	1,550,727.2
39	УРСГАЛ ЗАРДАЛ	1,441,462.9	1,342,637.1
40	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,394,814.7	1,302,605.2
41	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	739,286.7	684,018.9
42	Үндсэн цалин	401,102.3	387,696.9
43	Нэмэгдэл	266,080.3	255,908.5
44	Урамшуулал	72,104.1	40,413.5
45	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,411.1	87,107.6
46	Тэтгэврийн даатгал	62,839.4	60,320.5
47	Тэтгэмжийн даатгал	7,393	7,079.5
48	ҮОМШӨ-ний даатгал	3,696.5	3,613.1
49	Ажилгүйдлийн даатгал	3,696.5	3,126.6
50	Эрүүл мэндийн даатгал	14,785.7	12,967.9
51	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	389,911.7	379,285.3
52	Гэрэл, цахилгаан	33,071.9	24,554.8
53	Түлш, халаалт	350,849.9	351,075.5
54	Цэвэр, бохир ус	5,989.9	3,654.9
55	Хангамж, бараа материалын зардал	28,834.3	24,053.7
56	Бичиг хэрэг	5,212.5	3,393.6
57	Тээвэр, шатахуун	18,428.6	15,949.5
58	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,193.2	4,710.6
59	Эд хогшил, урсгал засварын зардал	17,647.5	14,359.2
60	Багаж, техник, хэрэгсэл	6,500	6,500
61	Урсгал засвар	11,147.5	7,859.2
62	Томилолт, зочны зардал	9,535.8	9,497.2
63	Дотоод албан томилолт	9,535.8	9,497.2
64	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,312.3	20,253.1
65	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,200	19,913.5
66	Даатгалын үйлчилгээ	469.1	0.0
67	Тээврийн хэрэгслийн татвар	227.7	114.2
68	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73.8	22

69	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.4	203.4
70	Газрын төлбөр	138.3	0.0
71	Бараа үйлчилгээний бусад зардал	86,875.3	84,030.2
72	Бараа үйлчилгээний бусад зардал	74,095.1	72,206.6
73	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,780.2	11,823.6
74	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,648.2	40,031.9
77	Бусад урсгал шилжүүлэг	46,648.2	40,031.9
78	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,512	6,996
79	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,136.2	32,136.2
80	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000	899.7
81	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	239,184.3	205,960.8
82	Бусад хөрөнгө	239,184.3	205,960.8
83	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,000	2,129.3
84	Эргэж төлөгдөх зээл	40,000	2,129.3
85	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-172,999	22,410.9
86	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	172,999	-22,410.9
87	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	172,999	-22,410.9
88	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	124,378.1
89	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	146,789.1
90	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	44	5
91	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	1
92	Төсвийн байгууллага	2	1
93	АЖИЛЛАГСДЫН ТОО	21	19
94	Удирдах ажилтан	10	8
95	Гүйцэтгэх ажилтан	8	8
96	Үйлчлэх ажилтан	3	3
97	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	19
98	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	8
99	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4
100	Улс төрийн албан хаагч (УТ)	8	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	19,597.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,597.21
122	Тусламжийн орлого	19,597.21
1221	Хандив тусламж /дотоод/	19,597.21
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,597.21
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,597.21
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,601.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,601.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,601.71
2104	Хангамж, бараа материалын зардал	1,308.05
210402	Тээвэр, шатахуун	1,308.05
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	573.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	573.67

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,720.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,720.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	3,995.50
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(3,995.50)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(3,995.50)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой 82.30 сая төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг гэж үзэж, 37.96 сая төгрөгийн тогтоосон материаллаг байдлын түвшнээс 44.34 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

3.2 Албан шаардлага

Аудитаар Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зарим иргэдийн зээлийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн хэрэгжээгүй зөрчилд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгсөн.

3.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Яруу сумын ЗДТГ												
Яруу сумын ИТХ												
Яруу сумын ОНХС												
Яруу сумын ХХС												
Яруу сумын Засаг дарга												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
Яруу сумын ЗДТГ	10	100,206.2	3	6,446.4	5	10,969.4	1	32,687.0	1	50,103.1		
Яруу сумын ИТХ												
Яруу сумын ОНХС	2	787,000.2			1	66,100.0	1	720,900.2				
Яруу сумын ХХС	1	16,202.0			1	16,202.0						
Яруу сумын Засаг дарга	1	82,302.0			1	82,302.0						
Дүн	14	985,710.5	3	6,446.4	8	175,573.8	2	753,587.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	4	1	3				1	
2	ТТЗ	1	1				1		
	НИЙТ	5	2	3			1	1	

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

Огноо: 2026-03-25

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Т.БААСАНЖАРГАЛ

Огноо: 2026-03-25

